



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/31

Номгон

Төрийн сангийн удирдлагын цахим
системд нэвтрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эдийн засгийн бодлого цахим шилжилтийн 3.1.12 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөвт байгууллагуудын төрийн сангаар хийж буй төлбөр тооцоог 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Төрийн сангийн удирдлагын цахим системээр дамжуулсугай.


2.Төрийн сангийн сургалтын системээс цахим төлбөр тооцооны хичээлийг судалж, төсвийн байгууллагын төлбөр тооцоог шинэ цахим системд нэвтрүүлэхийг бүх шатны төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3.Цахим төлбөр тооцоог үнэн зөв, алдаагүй, цаг хугацаанд нь нэвтрүүлж, цахим хичээлүүдийг бүрэн судалж, бусдадаа туршлагаасаа хуваалцаж, манлайлан ажилласан шилдэг санхүүгийн алба шалгаруулах уралдааны удирдамжийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Төрийн сангийн гүйлгээг цахимжуулах зардлыг 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Ц.Самбууням)-д зөвшөөрсүгэй

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310076

Аймгийн Засаг даргын..... оны дүгээр сарын
..... -ний өдрийн дүгээр захирамжийн
нэгдүгээр хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

УДИРДАМЖ

2023 оны 01 дүгээр сарын 19

Номгон

Баянхонгор аймгийн санхүүгийн албадын
төрийн сангийн удирдлагын цахим системээр
2023 онд цахим гүйлгээ нэвтрүүлэх тухай

Нэг. Зорилго:

Цахим төлбөр тооцоог сумын төсөвт байгууллагадаа үнэн зөв, алдаа, зөрчилгүй, цаг хугацаанд нь нэвтрүүлэх, цахим хичээлүүдийг бүрэн судлах, бусдадаа туршлага хуваалцах, манлайлан ажиллахад тус уралдааны зорилго оршино.

Хоёр. Хамрагдах байгууллага:

2.1 Аймгийн хэмжээний 20 сумын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудын хамт

Гурав. Хугацаа:

3.1 Төсөвт байгууллага цахимаар төлбөр тооцоог хийсэн тайланг сумын Засаг даргад 2023 оны 4 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлэх

3.2 Сумын санхүүгийн алба нь төсөвт байгууллагуудаас ирүүлсэн болзолт уралдааны тайланг нэгтгэн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2023 оны 4 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэх.

3.3 Санхүү төрийн сангийн хэлтэс нь сумдаас ирүүлсэн төрийн сангийн цахим шилжилтийн ажлын тайлантай танилцаж 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор дүгнэх.

Дөрөв. Болзол буюу хийгдэх ажил

4.1 Сумын санхүүгийн алба

4.1.1 Эрхийн бүртгэлийн санд хэрэглэгчийн эрхийн тохиргоог бүрэн хийх

4.1.2 Эрхийн бүртгэлийн санд хэрэглэгчийн мэдээлэл үнэн зөв байх

Лухайн хэрэглэгчийн ажилд томилогдсон шийдвэр, цахим мэдэгдэл, зөвшилцлийн бичиг, Гарын үсгийн баталгаа нотариатаар батлагдсан, тушаал, захирамжийн огноо, дугаар, гарын үсэг, тамга бүрэн эсэх/

2.

4.1.3 Байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогчдод эрхийн бүртгэлийн сан, портал системийн эрхийг үнэн зөв олгосон байна.

4.1.4 Ажлаас түр болон бүр чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон хэрэглэгчдийн тохиргоог тухай бүр хийх

4.1.5 Эрхийн бүртгэлийн санд төсвийн байгууллагын баримт бичгийн тохиргоог хийсэн байх

4.1.6 Төрийн албаны цалингийн системд зөвхөн цалин гарах үндсэн данс бүртгэх

4.1.7 Портал системд улсын төсвийн байгууллагын үндсэн, тогтмол зардлын данс, орон нутгийн төсвийн байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансыг бүртгэнэ.

4.1.8 Татварын системээс олгосон дугаар бүхий төрийн сангийн нэгжид татварын орлогын данс, татан төвлөрүүлэлт, ерөнхий орлогын данс, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн дансыг бүртгэх

4.1.9 Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогчдод хууль тогтоомжийн хүрээнд сургалт, зөвлөгөө өгөх.

4.1.10 Шинэ шилэн дансны системд төсөвт байгууллагууд 2023 онд мэдээллээ бүрэн байршуулахад хяналт тавих

4.1.11 Аймгийн Засаг даргын 2021 оны А683 дугаар захирамжийн хэрэгжилт шалгасан байх

4.1.12 Сангийн яамны <http://surgalt-ts.mof.gov.mn/> сургалтын системээс:

- Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн бүх хичээлийг бүрэн судлах
- Амлалт үүргийн хичээл бүрэн судлах, амлалт үүсгэсэн байх
- Төрийн сангийн удирдлагын цахим системийн хичээл бүрэн судлах
- Эрхийн бүртгэлийн сангийн хичээл бүрэн судлах

Эдгээр хичээлээр сертификат авсан байна

4.1.13 Шинэ санаа санаачилга гарган, үр дүнтэй ажилласан байдал

4.2. Сумын засаг дарга, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогчид

4.2.1 Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр цалин олгохдоо ажил үүргийн болон мэргэжлийн ёс зүйг баримтлах, ашиг сонирхол үүсгэхгүй байх

4.2.2 Сангийн яамны <http://surgalt-ts.mof.gov.mn/> сургалтын системээс:

3.

4.2.3.Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн бүх хичээлийг бүрэн судлах

- Амлалт үүргийн хичээл бүрэн судлах, амлалт үүсгэсэн байх
- Төрийн сангийн удирдлагын цахим системийн хичээл бүрэн судлах

Эдгээр хичээлээр сертификат авсан байна

4.2.4 Төсөвт байгууллагын төлбөр тооцоог finance.gov.mn системээр дамжуулан цахимаар хийх

4.2.5 Нягтлан бодогч finance.gov.mn системд харилцагч байгууллагаас үүсгэсэн нэхэмжлэлийг зааврын дагуу татаж, тухайн төлбөр тооцооны анхан шатны баримтыг бүрдүүлэн төлбөрийн хүсэлт үүсгэн, баталгаажуулж илгээх

4.2.6.Дарга, эрхлэгч finance.gov.mn системд нягтлан бодогчоос ирсэн төлбөрийн хүсэлт, анхан шатны баримтыг хянан баталгаажуулах, шаардлага хангаагүй бол буцаах

4.2.7. Дарга, эрхлэгч, нягтлан бодогчид цалингийн болон цахим гүйлгээний системийн эрхийг эрх бүхий албан тушаалтан ашиглах, өөр албан тушаалтан, хувь хүнд дамжуулахгүй байх

4.2.8. finance.gov.mn системийн тайлан цэсээс байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, орлого зарлагын хуулга, цахимаар хийгдсэн төлбөр тооцоог тухай бүр хянах, боловсруулах, тайлагнах

4.2.9.Шилэн дансны <https://gap.mof.gov.mn/> шинэ системд төсөвт байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг цаг тухай бүр үнэн зөв оруулах

4.2.10.Аймгийн Засаг даргын 2021 оны А683 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангасан байх

4.2.11 Шинэ санаа санаачилга гарган, үр дүнтэй ажилласан байдал

Тав.Уралдааныг дүгнэх

5.1 Санхүүгийн албанаас ирүүлсэн тайлан нь баримт бичгийн стандарт хангасан, ойлгомжтой байх. Тайланг microsoft powerpoint болон бичмэл хэлбэрээр баталгаажуулан ирүүлж болох бөгөөд бусад баримт материалыг хавсаргаж болно.

5.2 Төрийн сангийн удирдлагын цахим системээр төлбөр тооцоог хийхдээ анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийсэн, хянасан, цахим хичээлүүдийг бүрэн судалж, цаг тухай бүр төлбөр тооцоог шуурхай хийж, бусад сумдаа манлайлсан байдлаар

5.3 Санхүүгийн ажилтны тогтвор суурьшилтай ажиллуулах, ур чадварыг сайжруулах арга хэмжээ авсан байдал

4.


5.4 Санхүүгийн алба нь тус уралдааны тайланг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Санхүү, төрийн сангийн хэлтэст ирж хамгаална.

Зургаа. Шагналын сан

1. Нэгдүгээр байр өргөмжлөл, 1000,000 төгрөг
2. Хоёрдугаар байр өргөмжлөл, 800,000 төгрөг
3. Гуравдугаар байр өргөмжлөл, 500,000 төгрөг

_____оОо_____

Аймгийн Засаг даргын..... оны ...дүгээр сарын
.... –ний өдрийн..... дүгээр захирамжийн
хөёрдугаар хавсралт



**БАЯНХОНГОР АЙМАГТ ТӨРИЙН САНГИЙН
УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМД НЭВТРҮҮЛЭХ
ЗАРДАЛ**

№	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Төрийн сангийн төлбөр тооцоог цахим системд шилжүүлэх сургалт	2500,000
2	Төрийн сангийн удирдлагын цахим системээр гүйлгээг цахимаар дамжуулах уралдааны зардал	2550,000
3	Сумдын төрийн сангийн төлбөр тооцоог цахим системээр хийх үйл ажиллагаанд хяналт хийх	1350,000
4	Шаардлагатай тоног төхөөрөмж шинэчлэх	3600,000
5	Нийт	10,000,000

_____ оОо _____